



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/349

Булган сум

Тусгай зориулалтаар 2024 онд барих,
загасны дуудлага худалдааны ялагчтай
гэрээ байгуулах, эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 291 дүгээр зүйлийн 291.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Тусгай зориулалтаар 2024 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай” 89 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих, бусад төрлийн загас барих зөвшөөрөл олгох дуудлага худалдааны ялагчийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгай зориулалтаар тул загас барьж буцаан тавих, бусад төрлийн загас барих зөвшөөрөл олгох дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулж, тусгай зориулалтын агнуурын амьтныг агнах зөвшөөрлийн үнэ, төлбөр хураамжийг хуульд заасан хугацаанд, холбогдох дансанд төвлөрүүлж, дуудлага худалдааны ялагч нарт тусгай зөвшөөрөл олгох ажлыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

05 дугаар сарын 15 нын өдрийн АЗН дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР ТУЛ ЗАГАС БАРЬЖ БУЦААН ТАВИХ, БУСАД
ТӨРЛИЙН ЗАГАС БАРИХ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЯЛАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

д/д	Ялагчын нэр	Тул загас (бариад тавих)	Бусад загас	Дуудлага худалдаа	Төлвөл зохих Мөнгөн дүн (төгрөгөөр)
1	2	3	4	5	6
1	Ч.Батцэцэг	10	100	1-р багц	3,500,000
2	"Би Тү Бросс" ХХК	10	100	2-р багц	7,000,000
3	"Жаргал экспедишн" ХХК	10	100	3-р багц	8,750,000